

НЭЭЛТТЭЙ ЗАСГИЙН ТҮНШЛЭЛ (OGP)-ИЙН УЛС ТӨРИЙН НАМЫН САНХҮҮЖИЛТИЙН ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ СОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ЯВЦЫН МЭДЭЭЛЭЛ

2025 оны 5 дугаар сарын 01-ний өдөр

Улаанбаатар хот

Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо 2025 оны 2 дугаар сард Нээлттэй Засгийн түншлэлийн Сорилтод Улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдлыг хангах чиглэлээр нэгдэх хүсэлтээ өгсөн. Сонгуулийн ерөнхий хорооны санаачилгыг хянан үзэж батлан гэрчилгээ олгосоноор Ази тивээс Сорилтод нэгдсэн анхны улс болсон.

Монгол Улсын хувьд 2019 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн үзэл баримтлалд нийцүүлэн Улс төрийн намын тухай хуулийг 18 жилийн дараа бүхэлд нь шинэчлэн баталж, улс төрийн намыг улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг, санхүүжилт үйл ажиллагаа нь ил тод, хяналттай, хариуцлагатай, Үндсэн хуульт ардчиллын чухал институт, бодлогын нам болон хөгжиж, бэхжих эрх зүйн орчныг бүрдүүлсэн.

Сонгуулийн төв байгууллага энэхүү хуулийн хэрэгжилтийг бүрэн хангах, үр дүнтэй хэрэгжүүлэхэд анхаарал хандуулан ажиллаж байна.

Улс төрийн намын санхүүжилтийг зөвхөн мэдээлэх нь ил тод, хяналттай байдлыг бүрэн хэрэгжүүлэхэд төдийлөн хангалтгүй тул нээлттэй эх сурвалж /open data/ болгон ил тод нийтлэх нь олон нийтийн зүгээс бүрэн хяналт тавих боломжийг бүрдүүлэх ач холбогдолтой.

1. Нээлттэй Засгийн түншлэл (OGP)-ийн Сорилтод нэгдэв.

2025 оны хоёрдугаар сарын 5-7-ны өдрүүдэд Филиппин Улсын Манила хотноо болсон Нээлттэй Засгийн түншлэл (OGP)-ийн Ази, Номхон далайн гишүүн орнуудын Бүсийн чуулганд Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны төлөөлөгчид оролцож Сайд нарын түвшний хэлэлцүүлэгт сонгуулийн эрх зүйн шинэчлэлийн хүрээнд хэрэгжүүлж буй ажлууд, улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдлыг хангах цахим платформ хөгжүүлэн ашиглах талаар танилцуулсан.

Төлөөлөгчид Бүсийн чуулганы үеэр Нээлттэй Засгийн түншлэл, Нээлттэй нийгэм форум, Транспарэнси интернэшнл, Ардчилал сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэнгийн холбогдох төлөөлөгчидтэй уулзаж Сорилтыг хэрэгжүүлэхтэй холбоотой төлөвлөсөн ажлуудыг танилцуулсан. Уулзалтаар цахим систем нэвтрүүлсэн гадаад орнуудын туршлагаас судлах, цаашид хамтарч ажиллах донор байгууллагуудын оролцоо, хамтын ажиллагааны хүрээг тодорхойлох уулзалт, семинарыг 2025 оны 4 дүгээр сарын эхэнд Улаанбаатар хотод зохион байгуулахаар санал нэгдсэн.

2. “Улс төрийн намын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор улс төрийн намын санхүүжилтийн тайлангийн цахим системийн шаардлагыг тодорхойлох олон улсын туршлага” семинарын тухай

Нээлттэй Засгийн түншлэл (OGP)-ийн Ази, Номхон далайн гишүүн орнуудын Бүсийн чуулганы үеэр хийсэн уулзалтын дагуу Сонгуулийн ерөнхий хороо 2025 оны 4 дүгээр сарын 8, 9-ний өдрүүдэд Нээлттэй засгийн түншлэл, Нээлттэй нийгэм форум, Транспэрэнси Интернэшнл олон улсын байгууллага, Европын аюулгүй байдал хамтын ажиллагааны байгууллагатай хамтран зохион байгуулсан “Улс төрийн намын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор улс төрийн намын санхүүжилтийн тайлангийн цахим системийн шаардлагыг тодорхойлох олон улсын туршлага” семинарт Улсын дээд шүүхэд бүртгэлтэй 37 намын төлөөлөл, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл гээд 40 гаруй хүн танхимаар, 30 гаруй хүн цахимаар оролцлоо. Үүнд: улс төрийн намууд, Сангийн яам, Авлигатай тэмцэх газар, Үндэсний аудитын газар, Бодлогод залуусын хяналт төрийн бус байгууллага, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр зэрэг багтана.

Уг семинарт Транспэрэнси интернэшнл (Transparency International), Сонгуулийн тогтолцооны олон улсын сан (International Foundation for Electoral System), Армени улсын Авлигаас сэргийлэх комисс, Латви Улсын парламент, Английн Бристолийн Их Сургуулийн судлаач, мэргэжилтнүүд өөрийн орны болоод олон улсын туршлагаас танилцуулсан.

Семинарын хөтөлбөрийг хавсаргав.

2.1. Цахим системийн хөгжүүлэлтийн талаар туршлага судлав

Семинарын эхэнд Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран семинарыг нээж, улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд хийгдэх хамгийн том ажлын нэг болох улс төрийн намын санхүүжилтийн тайлангийн цахим системийн талаар туршлагаа хуваалцаж, дэмжлэг үзүүлж байгаа олон улсын байгууллага, бусад оролцогчдод талархлаа илэрхийлсэн. Түүний дараа Улс төрийн намын тухай хуулийн хэрэгжилт, санхүүжилтийн тайлан, ил тод байдлыг хангах талаар хийгдсэн ажил болон хууль, эрх зүйн үндэслэл, цахим системийн хөгжүүлэлтийн ерөнхий төлөвлөгөөний талаар Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын дарга Д.Бат-Эрдэнэ танилцуулсан.

Монгол Улс дахь улс төрийн намуудад төрөөс олгох санхүүжилт, санхүүжилтийг тайлагнах өнөөгийн байдал, санхүүгийн хяналтыг хэрэгжүүлэхэд тулгарч буй бэрхшээл, ил тод байдлыг хангаж ажиллахад шийдвэрлэх арга замын талаар Сонгуулийн ерөнхий хорооны Улс төрийн намын санхүүжилт, хяналтын газрын дарга Н.Булгамаа танилцуулж, “Улс төрийн намуудын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн хяналт, дүгнэлт”-ийн ажлыг хэрэгжүүлсэн гүйцэтгэл дээрээ тулгуурлан илтгэл хэлэлцүүлээ.

- Сонгуулийн тогтолцооны олон улсын сан (IFES)-ийн Улс төрийн санхүүжилт хариуцсан ахлах зөвлөх, Европын бүсийн газрын захирал Махнус Оман “Цахим ил тод байдал, дэлхийн улс орнуудын туршлага: Зарим бүс нутагт ил тод байдлыг хангахад ашиглаж буй цахим шийдэл” илтгэлдээ цахим системд тайлагнах, дүн шинжилгээ хийх, нээлттэй байршуулах олон улсын туршлагыг танилцуулсан. Тэрээр цахим системд тайлагнах заавар, гарын авлагыг боловсруулж, намын ажилтнуудыг тогтмол сургах шаардлагатайг зөвлөсөн юм.

Тайланг бүрэн эсэхийг хянах, хуульд заасан шаардлага хангасан эсэхийг нягтлах боломжоор хангахын тулд төрийн байгууллагууд мэдээлэл солилцож болохуйц систем хөгжүүлэх нь чухал болохыг онцолсон. Улмаар олон нийтэд ойлгомжтой, хуулах, татаж авах боломжтой системийн жишээг харуулж, цахим системийн дата мэдээллийг сэтгүүлч, судлаачдын хэрэгцээнд зориулан төрөл бүрээр, мэдээлэл авахад хялбар байдлаар нийтэлж, мэдээллийг эргэлтэд оруулснаар олон нийт хяналт тавих боломжтойг дурдлаа.

- Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Ардчилсан институт, хүний эрхийн алба (АИХЭА)-ны Хуулийн мэргэжилтэн Надя Сирэнко, Сонгуулийн зөвлөх Горан Пэтров, Улс төрийн намын Үндсэн багийн гишүүн Фернандо Касал Бэртоа нар Улс төрийн намын тухай хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийж Урьдчилсан зөвлөмжөө танилцуулав.

Жич: Сонгуулийн ерөнхий хорооны хүсэлтээр Европын аюулгүй байдал хамтын ажиллагааны байгууллагын Ардчилсан институт хүний эрхийн алба (АИХЭА) Улс төрийн намын тухай хуулийн хэрэгжилтэд үнэлгээ өгөх, холбогдох оролцогч талуудтай уулзахаар 4 дүгээр сарын 8-11-ний өдрүүдэд Улаанбаатар хотноо ажилласан.

- Улс төрийн намын санхүүжилтийг тайлагнах цахим шийдэл, Латви улсад намын санхүүжилтийг тайлагнахад EDIS цахим систем ашигладаг бөгөөд тус систем нь төрийн байгууллагаас намуудтай харилцах гүүр болохоос гадна техникийн түвшний шийдэл нь улстөржих эрсдлээс сэргийлж, оролцогчдод тохирох нэг хэмжээс ашиглахаас гадна өгөгдлийг хялбар боловсруулж, хянах боломжтой гэдгийг Европын аюулгүй байдал хамтын ажиллагааны байгууллага (ЕАБХАБ)-ын улс төрийн намын үндсэн багийн гишүүн бөгөөд Латви улсын парламентын гишүүн асан Лолита Сиганэ танилцуулсан.

Тэрээр илтгэлдээ, Санхүүгийн тайлангийн өгөгдөл оруулах систем нь мөнгөн, мөнгөн бус, бусад хандивыг оруулсан даруйд нийтэд мэдээлэх боломжтойгоос гадна орлого, зарлага нь автоматаар бүртгэгдэж, нэгтгэгддэг гээд, төрөөс олгосон санхүүжилтийг хэрхэн ашиглаж буйг системээр олон нийт хянах боломжтой.

Тайлангийн систем дэх мэдээлэл нийтэд нээлттэй бөгөөд мэдээлэл боловч дүн шинжилгээ хийх, хандивлагч өөрийн хандиваа хянах боломжтой аж. Тухайлбал, хувийн эх үүсвэрээс орж ирсэн хандивыг бүтцийн хувьд хэмжээ, давтамж, идэвхтэй

дэмжигч, тэдний ажилладаг салбар зэрэг үзүүлэлтээр тоймлодог. Мөн улс төрийн нам, хандивын ангилал, хандивлагчийн мэдээлэл, цаг хугацаа зэрэг сонголтоор хайлт хийх мэдээллийн сан бүрдүүлжээ. Цахим системээс гадна тайлангийн аппликэйшн нэвтрүүлсэн нь өргөн хэрэглээтэй байдгийг дурдсан юм.

Английн Бристолийн Их сургуулийн Улс төрийн тэнхимийн профессор, доктор Сэм Пауэр өөрийн илтгэлдээ хиймэл оюун ухааны тусламжтайгаар намын санхүүжилтийн ил тод байдлыг хангах, хянах боломж, сорилтын талаар танилцуулсан.

Сонгууль эрхэлсэн байгууллагын нөөц, сонгууль зохион байгуулах цаг хугацаа хязгаарлагдмал тул хиймэл оюун ухаан ашиглах шаардлагатайг тэрбээр дурдаад зөв ашиглаж чадвал олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх ач холбогдолтойг онцолсон юм. Хиймэл оюун ухаан нь их хэмжээний өгөгдлийг богино хугацаанд хямд өртгөөр боловсруулах боломжтой. Англи улс сонгуулийн төв байгууллагад ирүүлсэн нэхэмжлэхийн шинжилгээнд суурилан хиймэл оюун ухааны арга хэрэгсэл хөгжүүлж байгаа бөгөөд PDF файлаар нүүр танин системд оруулж, ангилснаар хиймэл оюун ухаан ашиглах өгөгдлийн сан бүрдүүлсэн байна.

Хиймэл оюун ухааныг нэвтрүүлснээр хяналт тавих, авлигаас сэргийлэх, авлигын эсрэг “Улаан туг” систем ашиглах боломж бүрдэхээс гадна нягтлан бодох туршлагыг стандартжуулах, мэдээлэл ил тод нээлттэй болох зэрэг ач холбогдолтой, нөгөө талаар хуулийн орчинг бүрдүүлэх, албан хаагчдын ур чадварыг нэмэгдүүлэх, итгэлцлийг бүрдүүлэх зэрэг сорилт тулгардаг болохыг дурдсан.

- Бодлогод залуусын хяналт ТББ нь нам, эвсэл, сонгуулийн зардлын тайланд хяналт үнэлгээ хийснийг тус байгууллагын Удирдах зөвлөлийн дарга Ц.Мандхайхатан танилцуулж, улс төрийн намуудын санхүүжилт, зардлын тайлангийн ил тод байдал хэрхэн хангагдаж байгаа болон иргэний нийгмийн байгууллага, олон нийт мэдээлэл авахад тулгарч буй бэрхшээлийг тодорхой жишээгээр тайлбарлаж, тайланд баримтын тулгалт хийхэд тодорхой зөрчил гарч байсныг онцолсон.

Улс төрийн намын санхүүжилтийн цахим системийн хэрэгцээг тодорхойлов

Семинарын хоёр дахь өдөр оролцогчид хэрэглэгчдийн бүлэгт хуваагдаж цахим системийн хэрэгцээг тус бүр тодорхойлон хэлэлцүүлэг өрнүүлсэн.

Хэлэлцүүлгээр санхүүжилтээ тайлагнах улс төрийн намууд хуульд заасан цаг хугацааг цахим системд хуваарь болгон оруулах, хувь хүний нууцлал, аюулгүй байдлыг хангах мөн хандивлагчийн лавлагаа, мэдээллийг татаж авах, хуульд заасан шаардлага хангасан эсэхийг шалгах шийдэлтэй байх, тайланг олон байгууллагад явуулдаг байдлыг хялбарчилж, төрийн байгууллагуудын уялдааг хангах хэрэгцээг оролцогчид онцолж байлаа.

Системээс мэдээлэл авах хэрэглэгчдийн төлөөлөл болох иргэний нийгмийн байгууллагууд хандивлагчдын мэдээллийг компани, хэр хэмжээний хандивыг хэдэн намд өгсөн, эзэмшигч нь хэн болох зэрэг мэдээллийг олон төрлөөр боловсруулж,

ангилсан мэдээлэл харах, тайланг бүлэглэсэн байдлаар болон ерөнхийгөөр татаж авах боломжтой байх шаардлагатайг илэрхийлсэн.

Мөн төрийн санхүүжилт зарлах, авах, зарцуулах зэрэг бүх үйл явцын мэдээлэл, намуудын хөрөнгө, хандивлагчийн хамаарал бүхий компаниудыг ангилсан байдлаар харах боломжийг бүрдүүлэх хэрэгцээг тодорхойлсон.

Семинарт оролцогчид цахим системийн шаардлагыг тодорхойлохдоо хандивлагчийн мэдээллийг оруулахад голчлон саналаа хэллээ.

Тиймээс цахим системийн эхний ээлжийн хөгжүүлэлт хандивт түлхүү анхаарахыг семинар зохион байгуулагчид зөвлөсөн бөгөөд цахим системийн шаардлага тодорхойлох, ажлын даалгавар бэлтгэх, хөгжүүлэхэд хамтран ажиллахыг хэрэглэгч болох улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллагуудаас хүссэн болно.

Семинарт оролцогч талуудын хүсэл сонирголоо илэрхийлсэн ажлын даалгаварт бэлтгэсэн гүйцэтэлийн хуудсыг баг тус бүрээр нэгтгэн, цаашид цахим системийн хөгжүүлэлтийн багт өгөхөд бэлэн болгов.

3. Дүгнэлт

2019 онд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтийн хүрээнд Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2023 оны 07 сарын 07-нд баталсан.

Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгад улс төрийн намыг бодлогын институт болгон төлөвшүүлэх, дотоод ардчиллыг дэмжиж бэхжүүлэх, намын санхүүжилтийн ил тод байдал, хяналтыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн бөгөөд улс төрийн намд төрийн санхүүжилт олгох, төрөөс шууд бус дэмжлэг үзүүлэх, улс төрийн намын мэдээллийн сан бүрдүүлэх, нийтэд мэдээлэх талаар болон хэрэгжилтийг хангах чиг үүргийн зохицуулалтыг ч нарийвчлан тусгаж өгсөн.

Хуулийг бүрэн хэрэгжүүлэхэд намд төрөөс олгох санхүүжилт, түүнийг хэрхэн олгох, санхүүгийн ил тод байдал, үйл ажиллагаанд хэрхэн хяналт тавих зэрэг нарийвчилсан зохицуулалтыг бүрэн хангаж, намын хандивын бүртгэлийг цахимжуулж, нээлттэй өгөгдлийн сан ашиглаж, санхүүгийн тайлан хүлээн авах, хянах, тайлагнах үйл ажиллагаа нийтэд ил тод, хүндрэлгүй байх, мөн энэхүү ажлыг зохион байгуулахад цахим систем, программ хангамжийг хөгжүүлэх нь нэн чухал байгааг Улсын дээд шүүхэд бүртгэлтэй 37 намын төлөөлөл, Сангийн яам, Үндэсний аудитын газар, Авилгатай тэмцэх газар гэх мэт төрийн байгууллагууд болон олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх иргэний нийгмийн байгууллагууд ч илэрхийлсэн нь хуулийн үзэл баримтлалыг нэг мөр ойлгосон үр дүнтэй олон улсын туршлагад тулгуурласан амжилттай хурал, семинар боллоо.

СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО

СЕМИНАРЫН ХӨТӨЛБӨР
2025 оны 4-р сарын 8-ны өдөр, Мягмар гариг

1-Р ХЭСЭГ

Үйл ажиллагаа: Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын дарга Д.Бат-Эрдэнэ удирдан явуулна.			
8:30 — 9:00	30'	Бүртгэл	
9:00 - 9:10	10'	Нээлт	П.Дэлгэрнаран Сонгуулийн ерөнхий хорооны дарга
9:10 - 9:30	20'	Илтгэл: Улс төрийн намын тухай хуулийн хэрэгжилт, санхүүжилтийн тайлан, ил тод байдлыг хангах талаар хийгдсэн ажил 1. Хууль, эрх зүйн үндэслэл 2. Санхүүгийн тайлан мэдүүлэх, ил тод байдлыг хангахад цахим систем ашиглахын давуу тал (тайлан гаргагч улс төрийн намууд, СЕХ, иргэний нийгмийн байгууллагууд). Нээлттэй засаглалын түншлэлийн (OGP) сорилтын тухай 3. Цахим системийг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө	Д.Бат-Эрдэнэ Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын дарга
9:30— 10:00	30'	Илтгэл: Улс төрийн намын санхүүжилт, санхүүжилтийг тайлагнах өнөөгийн байдал, тулгарч буй бэрхшээл, системийн төсөөлөл	Н.Булгамаа Сонгуулийн ерөнхий хорооны Улс төрийн намын санхүүжилт хяналтын газрын дарга
10:00- 10:20	20'	Цайны завсарлага	

10:20– 11:05	45'	Илтгэл: Цахим ил тод байдал, дэлхийн улс орнуудын туршлага: Зарим бүс нутагт ил тод байдлыг хангахад ашиглаж буй цахим шийдэл	Доктор Махнус Оман Сонгуулийн тогтолцооны олон улсын сан (IFES)-гийн Улс төрийн санхүүжилт хариуцсан ахлах зөвлөх, Европын бүсийн газрын захирал
11:05 - 11:20	15'	Асуулт, хариулт	
11.20-12.05	45'	Илтгэл: Улс төрийн намын тухай хуульд хийсэн үнэлгээ, урьдчилсан дүгнэлт	Горан Пэтров, Европын аюулгүй байдал хамтын ажиллагааны байгууллага (ЕАБХАБ)-ын Сонгуулийн зөвлөх, Надя Сирэнко, Европын аюулгүй байдал хамтын ажиллагааны байгууллага (ЕАБХАБ)-ын Хуулийн мэргэжилтэн, Фэрнандо Касал Бэртоа, Европын аюулгүй байдал хамтын ажиллагааны байгууллага (ЕАБХАБ)-ын улс төрийн намын Үндсэн багийн гишүүн
12:05 – 12:20	15'	Асуулт, хариулт	

12:20 – 13:30	70'	Үдийн цай - Силк роуд ресторан
------------------	-----	--------------------------------

13:30 – 14:00	30'	Илтгэл: Улс төрийн намын санхүүжилтийг тайлагнах, цахим шийдэл, Латви Улсын жишээ (цахимаар оролцоно)	Лолита Сиганэ, Европын аюулгүй байдал хамтын ажиллагааны байгууллага (ЕАБХАБ)-ын улс төрийн намын Үндсэн багийн гишүүн, Латвийн парламентын гишүүн асан
14:00 – 14:45	45'	Илтгэл: Ил тод байдлыг хангах цахим систем хөгжүүлсэн тухай: Армени улсын жишээ Армени Улсын Авлигаас сэргийлэх комисс улс төрийн намын санхүүгийн тайланг цахим системийн туршлага (цахимаар оролцоно)	Лилит Алексанян, Армени Улсын Авлигаас сэргийлэх комиссын гишүүн
14:45-15:00	15'	Асуулт хариулт	
15:00 – 15:20	20'	<i>Цайны завсарлага</i>	
15:20 – 15:45	25'	Илтгэл: Улс төрийн намын санхүүгийн тайлангийн цахимжилт (цахимаар оролцоно)	Доктор Сэм Пауэр, Английн Бристолийн Их сургуулийн улс төрийн тэнхимийн профессор
15:45 – 16:10	25'	Илтгэл: Нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланд хийсэн хяналт үнэлгээ — туршлага	Ц.Мандхайхатан, Бодлогод залуусын хяналт ТББ
16:10-16.20	10'	Асуулт хариулт	
16.20 – 16.30	10'	Эхний өдрийн хаалт	Д.Бат-Эрдэнэ, Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын дарга

Үйл ажиллагаа: Нээлттэй нийгэм форум – Д.Энхцэцэг удирдан явуулна.			
9:00 - 9:20	20'	Хоёрдугаар хэсгийн танилцуулга Цахим систем хэрэглэгчийн шаардлага хэрэгцээг тодорхойлох	Хөрхэ Валладарэс, <i>Улс төрийн шударга байдлын ахлагч, Транспэрэнси Интернэшнл</i>
9:20 - 10:20	60'	Хэрэглэгчийн хэрэгцээг тодорхойлох: Оролцогчид “хэрэглэгчийн үүрэг” бүлгүүдэд хуваагдана:	<i>Бүх оролцогчид</i>

		• Улс төрийн нам • Сонгуулийн ерөнхий хороо, Үндэсний аудит • Олон нийт, хэрэглэгчид Эдгээр бүлгүүд нь системийн хөгжүүлэлтийн явцад шаардлагатай болох үйл ажиллагааны бүх шаардлага хэрэгцээг тодорхойлно.	
10:20 - 10:40	20'	<i>Цайны завсарлага</i>	
10:40 - 11:10	30'	Санал хүсэлт 1 бүлэг: Улс төрийн нам Тайлан гаргах үйл явцыг цахим систем ашигласнаар илүү үр ашигтай, нарийн зөв гаргахад уг системээс шаардлагатай, хэрэгтэй юу байх талаар танилцуулж, тайлбарлана. Танилцуулгад санал зөвлөмж өгнө.	<i>Бүлгийн төлөөлөл</i>
11:10 - 11:40	30'	Санал хүсэлт 2 бүлэг: Сонгуулийн ерөнхий хороо, Үндэсний аудит Уг бүлэг нь цахим системд хандалтын түвшиний талаар, системийн анализ хийх мэдээллийн төрөл, бусад функцийг танилцуулж, тайлбарлана. Үүнд санал өгнө.	<i>Бүлгийн төлөөлөл</i>
11:40 - 12:10	30'	Санал хүсэлт 3 бүлэг: Олон нийт, хэрэглэгчид Уг бүлэг нь олон нийтэд ямар төрлийн мэдээллийг ямар форматаар авах хүсэлтэй байгааг мөн ямар нөхцөлд нээлттэй болон хяналт тавих боломж бүрдэх шаардлагатайг танилцуулна. Санал өгнө.	<i>Бүлгийн төлөөлөл</i>

12:10 – 12:25	15’	Хэрэглэгчдийн хэрэгцээний талаарх бүлгүүдийн санал, тойм	<i>Д.Энхцэцэг, Нээлттэй нийгэм форум</i>
12:30 - 13:30	60’	<i>Үдийн цай - Силк роуд ресторан</i>	
13:30 - 14:15	45’’	Цахим систем хөгжүүлэх төлөвлөгөө, дараагийн алхам: СЕХ-ноос цахим систем хөгжүүлэх төлөвлөгөө хийгдэх ажлын талаар бүх оролцогчдод танилцуулна.	<i>Сонгуулийн ерөнхий хороо</i>
14:15 - 14:30	15’	Хаалт	<i>Сонгуулийн ерөнхий хороо</i>